БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
3. Аудитын тайлан 12
3.1 Ерөнхий зүйл 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 14
3.4 Материаллаг байдал 14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 16
3.8 Аудитын гол асуудал 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 17
4. Аудитын илрүүлэлт 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НА	Нийцлийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХГБХЗХ	Хүүхэд гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 97

танай_____ны №_____т

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Д.АЛТАНШАГАЙ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020164

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**699,842,389.76**	**81,035,522.81**
33	**АВЛАГА**	625,340,000.00	11,113,333.05
335	**Бусад авлага**	625,340,000.00	11,113,333.05
3351	Байгууллагаас авах авлага	605,000,000.00	773,333.05
3352	Хувь хүмүүсээс авах авлага	20,340,000.00	10,340,000.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	74,502,389.76	69,922,189.76
351	**Түүхий эд материал**	16,262,000.00	9,318,000.00
35110	Тусгай зориулалттай материал	16,262,000.00	9,318,000.00
354	**Хангамжийн материал**	58,240,389.76	60,604,189.76
35410	Бичиг хэргийн материал	1,365,000.00	922,000.00
35420	Аж ахуйн материал	45,920,839.76	39,790,639.76
35440	Түлш, шатах тослох материал	2,080,000.00	490,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,874,550.00	19,401,550.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**5,413,059,072.90**	**5,562,386,547.50**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	5,413,059,072.90	5,562,386,547.50
391	Газар	135,278,000.00	135,278,000.00
392	**Биет хөрөнгө**	5,277,093,572.90	5,425,962,714.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,317,296,794.93	5,317,296,794.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	(356,114,213.30)	(449,055,509.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	354,400,000.00	491,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(321,388,889.18)	(229,294,444.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	332,515,080.58	379,706,161.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(214,377,855.75)	(241,352,195.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	253,613,988.28	277,094,240.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(139,856,734.58)	(165,493,754.50)
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,327,770.00	59,327,770.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,322,368.08)	(13,266,348.88)
393	**Биет бус хөрөнгө**	687,500.00	1,145,833.33
39301	Програм хангамж	4,800,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,112,500.00)	(104,166.67)
39303	Бусад биет бус хөрөнгө	34,209,600.00	5,654,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(34,209,600.00)	(5,654,000.00)
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**6,112,901,462.66**	**5,643,422,070.31**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**605,000,000.00**	**-**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	605,000,000.00	-
413	**Өглөг**	605,000,000.00	-
4136	**Бусад өглөг**	605,000,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	605,000,000.00	-
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**5,507,901,462.66**	**5,643,422,070.31**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	5,507,901,462.66	5,643,422,070.31

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,104,006,679.64	1,104,006,679.64
51101	Өмч: - төрийн	1,104,006,679.64	1,104,006,679.64
512	**Хуримтлагдсан үр дүн**	3,409,638,456.59	3,545,159,064.24
51210	Өмнөх үеийн үр дүн	3,409,638,456.59	3,409,638,456.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	135,520,607.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	994,256,326.43	994,256,326.43
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**6,112,901,462.66**	**5,643,422,070.31**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**1,333,394,162.00**	**3,037,543,319.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**10,912,800.00**	**287,856,071.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	10,912,800.00	287,856,071.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,912,800.00	287,856,071.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,912,800.00	9,177,105.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	278,678,966.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**1,322,481,362.00**	**2,749,687,248.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	913,410,500.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	913,410,500.00	-
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	152,905,862.00	357,229,748.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	27,108,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000.00	182,234,708.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,905,862.00	147,887,040.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	256,165,000.00	2,392,457,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	256,165,000.00	2,392,457,500.00
2	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**1,061,430,187.47**	**2,891,041,779.46**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**1,061,430,187.47**	**2,891,041,779.46**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	1,012,336,629.47	2,508,081,847.29
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	439,694,974.00	930,303,370.00
210101	Үндсэн цалин	432,032,991.00	486,162,820.00
210102	Нэмэгдэл	-	219,096,571.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,098,268.31
210105	Гэрээт ажлын хөлс	7,661,983.00	203,945,710.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	50,116,220.15	110,769,366.13
210201	Тэтгэврийн даатгал	34,175,741.20	77,284,140.07

210202	Тэтгэмжийн даатгал	3,880,255.72	8,320,495.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,104,203.78	6,584,355.82
210204	Ажилгүйдлийн даатгал	736,808.88	1,519,563.52
210205	Эрүүл мэндийн даатгал	8,219,210.58	17,060,811.44
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	123,605,392.00	217,372,954.50
210301	Гэрэл, цахилгаан	5,762,881.00	10,525,904.50
210302	Түлш, халаалт	111,575,723.00	195,578,273.00
210303	Цэвэр, бохир ус	6,266,788.00	11,268,777.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	78,495,632.00	97,504,692.85
210401	Бичиг хэрэг	1,935,950.00	13,087,910.00
210402	Тээвэр, шатахуун	20,021,500.00	49,630,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,650,387.00	13,071,672.85
210404	Ном, хэвлэл	48,041,895.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	2,027,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	845,900.00	15,882,910.00
210408	Бараа материал акталсны зардал	-	3,805,000.00
2105	**Норматив зардал**	1,577,500.00	2,513,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,577,500.00	2,411,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	102,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	5,748,100.00	44,602,115.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,905,500.00	-
210604	Урсгал засвар	1,842,600.00	44,602,115.00
2107	**Томилолт, зочны зардал**	13,042,950.00	56,011,160.00
210702	Дотоод албан томилолт	5,331,400.00	29,932,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	7,711,550.00	26,079,160.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	86,765,545.00	265,413,215.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,160,560.00	258,883,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,054,600.00	3,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,225.00	472,215.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,325,500.00	1,505,700.00
210807	Газрын төлбөр	80,860.00	520,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	213,290,316.32	783,591,973.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	113,118,361.00	515,115,868.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,669,220.00	73,638,376.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,502,735.32	194,837,729.51
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	49,093,558.00	382,959,932.17
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	49,093,558.00	86,080,054.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,000,000.00	60,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,244,168.00	7,800,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,849,390.00	18,279,854.00

2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	-	296,879,878.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	296,879,878.17
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)**	**271,963,974.53**	**146,501,539.54**
225	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН**	5,000,000.00	10,980,931.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,000,000.00	10,980,931.89
4	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)**	(5,000,000.00)	(10,980,931.89)
5	**НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)**	**266,963,974.53**	**135,520,607.65**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	**2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	1,104,006,679.64	994,256,326.43	3,496,686,947.13	**5,594,949,953.20**
C03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**1,104,006,679.64**	**994,256,326.43**	**3,496,686,947.13**	**5,594,949,953.20**
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	266,963,974.53	**266,963,974.53**
C08	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**1,104,006,679.64**	**994,256,326.43**	**3,409,638,456.59**	**5,507,901,462.66**
D01	**2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**1,104,006,679.64**	**994,256,326.43**	**3,409,638,456.59**	**5,507,901,462.66**
D03	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**1,104,006,679.64**	**994,256,326.43**	**3,409,638,456.59**	**5,507,901,462.66**
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	135,520,607.65	**135,520,607.65**
D09	**2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл**	**1,104,006,679.64**	**994,256,326.43**	**3,545,159,064.24**	**5,643,422,070.31**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**3,087,999,195.00**	**3,363,864,353.00**
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**18,269,800.00**	**614,177,105.00**
120	**Нийтлэг татварын бус орлого**	18,269,800.00	614,177,105.00
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	18,269,800.00	614,177,105.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,269,800.00	9,177,105.00

1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	605,000,000.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**3,069,729,395.00**	**2,749,687,248.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	1,629,420,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,629,420,900.00	-
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	1,050,076,895.00	357,229,748.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	27,108,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	754,992,000.00	182,234,708.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	213,571,266.00	147,887,040.00
1320	**Орон нутгийн төсвөөс санхүүжих**	390,231,600.00	2,392,457,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	390,231,600.00	2,392,457,500.00
2	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)**	**3,049,500,795.00**	**3,286,461,683.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**3,049,500,795.00**	**3,286,461,683.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**2,249,730,368.73**	**2,903,501,751.83**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	913,671,923.00	930,548,422.12
210101	Үндсэн цалин	485,090,984.19	484,871,683.99
210102	Нэмэгдэл	202,629,005.01	222,290,604.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18,912,878.17	21,098,262.31
210104	Урамшуулал	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	207,039,055.63	202,287,871.63
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	108,153,253.73	111,297,647.18
210201	Тэтгэврийн даатгал	81,243,189.07	77,812,421.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,680,053.31	8,320,495.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,332,692.37	6,584,355.82
210204	Ажилгүйдлийн даатгал	401,517.14	1,519,563.52
210205	Эрүүл мэндийн даатгал	16,495,801.84	17,060,811.44
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	222,156,828.00	217,372,954.50
210301	Гэрэл, цахилгаан	10,665,811.00	10,525,904.50
210302	Түлш, халаалт	199,982,091.00	195,578,273.00
210303	Цэвэр, бохир ус	11,508,926.00	11,268,777.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	129,942,306.00	79,614,292.85
210401	Бичиг хэрэг	10,995,550.00	11,822,960.00
210402	Тээвэр, шатахуун	51,874,380.00	48,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,980,481.00	13,071,672.85
210404	Ном, хэвлэл	48,041,895.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	4,208,430.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,050,000.00	2,511,230.00

2105	**Нормативт зардал**	3,324,150.00	5,053,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,999,150.00	2,549,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,325,000.00	2,504,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	17,600,520.00	50,719,665.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	403,570.00	165,000.00
210604	Урсгал засвар	17,196,950.00	50,554,665.00
2107	**Томилолт, зочны зардал**	38,081,200.00	57,997,060.00
210702	Дотоод албан томилолт	20,581,400.00	28,000,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	17,499,800.00	29,997,060.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	256,832,523.00	270,500,215.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	247,076,930.00	263,970,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,348,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,054,600.00	3,900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	418,225.00	472,215.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,325,500.00	1,505,700.00
210807	Газрын төлбөр	488,268.00	520,000.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	559,967,665.00	1,180,398,345.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	515,526,737.00	1,090,030,139.18
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,440,928.00	90,368,206.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**799,770,426.27**	**382,959,931.17**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	104,349,146.60	86,080,053.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,000,000.00	60,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	73,216,400.00	7,800,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,132,746.60	18,279,853.00
2134	**Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт**	695,421,279.67	296,879,878.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	695,421,279.67	296,879,878.17
3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**38,498,400.00**	**77,402,670.00**
5	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)**	**38,498,400.00**	**77,402,670.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**38,498,400.00**	**77,402,670.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	38,498,400.00	77,402,670.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,498,400.00	77,402,670.00
6	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**(38,498,400.00)**	**(77,402,670.00)**
8	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	-	-

9	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	-	-
10	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт -, Хэмнэлт +
1	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**			
2	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	2,430,457,500.00	2,221,025,033.83	209,432,466.17
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	2,430,457,500.00	2,221,025,033.83	209,432,466.17
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	2,344,357,300.00	2,134,944,980.83	209,412,319.17
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	924,477,700.00	916,745,846.12	7,731,853.88
210101	Үндсэн цалин	479,171,700.00	484,071,683.99	(4,899,983.99)
210102	Нэмэгдэл	253,626,900.00	222,290,604.19	31,336,295.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,800,000.00	21,098,262.31	1,701,737.69
210104	Урамшуулал	-	800,000.00	(800,000.00)
210105	Гэрээт ажлын хөлс	168,879,100.00	188,485,295.63	(19,606,195.63)
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	124,804,500.00	109,608,555.18	15,195,944.82
210201	Тэтгэврийн даатгал	87,825,300.00	76,123,329.12	11,701,970.88
210202	Тэтгэмжийн даатгал	9,244,800.00	8,320,495.28	924,304.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,395,800.00	6,584,355.82	811,444.18
210204	Ажилгүйдлийн даатгал	1,849,000.00	1,519,563.52	329,436.48
210205	Эрүүл мэндийн даатгал	18,489,600.00	17,060,811.44	1,428,788.56
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	223,229,400.00	217,372,954.50	5,856,445.50
210301	Гэрэл, цахилгаан	10,895,000.00	10,525,904.50	369,095.50
210302	Түлш, халаалт	201,634,400.00	195,578,273.00	6,056,127.00
210303	Цэвэр, бохир ус	10,700,000.00	11,268,777.00	(568,777.00)
2104	**Хангамж, бараа материалын зардал**	81,764,000.00	79,774,292.85	1,989,707.15
210401	Бичиг хэрэг	12,000,000.00	11,982,960.00	17,040.00
210402	Тээвэр, шатахуун	45,000,000.00	48,000,000.00	(3,000,000.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,764,000.00	13,071,672.85	1,692,327.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	4,208,430.00	791,570.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	2,511,230.00	(511,230.00)
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,000,000.00	-	3,000,000.00

2105	**Норматив зардал**	6,000,000.00	5,053,150.00	946,850.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,000.00	2,549,150.00	450,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,000,000.00	2,504,000.00	496,000.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	90,260,000.00	88,396,565.00	1,863,435.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,520,000.00	23,493,200.00	26,800.00
210602	Тавилга	15,000,000.00	13,216,000.00	1,784,000.00
210604	Урсгал засвар	51,740,000.00	51,687,365.00	52,635.00
2107	**Томилолт, зочны зардал**	58,000,000.00	57,997,060.00	2,940.00
210702	Дотоод албан томилолт	28,000,000.00	28,000,000.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	30,000,000.00	29,997,060.00	2,940.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	101,746,000.00	101,529,915.00	216,085.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	95,000,000.00	95,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,900,000.00	3,900,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	594,000.00	472,215.00	121,785.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,600,000.00	1,505,700.00	94,300.00
210807	Газрын төлбөр	520,000.00	520,000.00	-
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	734,075,700.00	558,466,642.18	175,609,057.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	643,335,200.00	499,444,656.18	143,890,543.82
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	90,740,500.00	59,021,986.00	31,718,514.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	86,100,200.00	86,080,053.00	20,147.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	86,100,200.00	86,080,053.00	20,147.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	60,000,000.00	60,000,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	7,800,200.00	7,800,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,300,000.00	18,279,853.00	20,147.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,430,457,500.00	2,401,634,605.00	28,822,895.00
1310	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	1,779,727,100.00	1,779,727,100.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,779,727,100.00	1,779,727,100.00	-
1320	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	642,730,400.00	612,730,400.00	30,000,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	642,730,400.00	612,730,400.00	30,000,000.00

120004	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	8,000,000.00	9,177,105.00	(1,177,105.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	9,177,105.00	(1,177,105.00)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**962,229,748.00**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**962,229,748.00**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	962,229,748.00
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	13,802,576.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,802,576.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	1,689,092.00
210201	Тэтгэврийн даатгал	1,689,092.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	168,970,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	168,970,300.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	746,407,473.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	715,061,253.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,346,220.00
2133	**Олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**31,360,307.00**
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	31,360,307.00
II	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	962,229,748.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	962,229,748.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	27,108,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	802,608,342.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,513,406.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,000,000.00
IV	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)**	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн

тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/94 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Иргэдээ дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлж, цахим технологид тулгуурласан, төрийн үйлчилгээнд шилжиж, аймгийнхаа хөгжил дэвшлийг оновчтой бодлого зохицуулалтаар хангасан ёс зүйтэй, мэргэшсэн төрийн захиргааны байгууллага байх зорилго дэвшүүлэн, үйл ажиллагаандаа өндөр мэргэшлийн, мэдрэмжтэй, хариуцлагатай, шуурхай, ил тод байх зарчмыг баримтлан ажиллах зорилтын хүрээнд дараах чиглэлийг баримтан ажиллалаа. Үүнд:

- Нутгийн захиргааны байгууллагын бодлого, шийдвэрт иргэдийн оролцоог хангах,
- Байгууллагын нээлттэй, ил тод, байдлыг өргөжүүлж, төрийн албанд бүтээлч санал, санаачлага, шилдэг арга зүйг нэвтрүүлэх,
- Байгууллагын үйлчилгээний чанар хүртээмж, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх,
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажилласан байна.

Булганчууд-2021 айрагны өдөрлөг, эвент арга хэмжээнүүд, БНЧУ, АНУ, БНСУ, БНБУ, Унгар улсын элчин сайд, холбогдох албан тушаалтнууд албан ёсны айлчлал арга хэмжээ, гэрээ хэлэлцээр, Аймгийн Засаг даргын тамгын газарт ISO-9001 2015 чанарын менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлжээ. Бүтээмж-чанарын жилийн аян, Үндэсний өв бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх жил болгон зарлаж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,494,845.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 34,948.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 85 хувиар буюу 29,706.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	625,340.00	11,113.33	(614,226.67)
Бараа материал	74,502.39	69,922.19	(4,580.20)
Үндсэн хөрөнгө	5,413,059.07	5,562,386.55	149,327.48
Нийт хөрөнгө	**6,112,901.46**	**5,643,422.07**	**(469,479.39)**
Богино хугацаат өр төлбөр	605,000.00	-	(605,000.00)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,507,901.46	5,646,422.07	138,520.61
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**6,112,901.46**	**5,646,422.07**	**(466,479.39)**

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 1,779,727.1 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгө 612,730.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 962,229.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 9,177.1 мянган төгрөгийг бүрдүүлэн нийт 3,363,864.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 3,066,984.4 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 296,879.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 11,113.3 мянган төгрөг болж, 614,226.7 мянган төгрөгөөр буурсан нь иргэн М.Оюунбатын орон сууцны төлбөрийн үлдэгдлээс 10,000.0 мянган төгрөг, ГОК-оос санхүүжүүлэх нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмж, гүүрний засвар, диваажингийн сүмын засварын зардлг тайлант онд аваагүйгээс нэмэлт санхүүжилтийг авлагыг үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,922.2 мянган төгрөг болж, 4,580.2 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал, аж ахуйн материал акталснаас нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,562,386.5 мянган төгрөг болж, 149,327.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, программ хангамж зэргийг бэлтгэж, Засаг даргын нөөц хөрөнгөөс бэлтгэсэн хөрөнгийг тухайн байгууллагад шилжүүлж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил акталснаас нөлөөлжээ.

Тайлант хугацааны эцэст өглөггүй ажилласан, өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү бичилт хийгдээгүй, тайлант онд хөрөнгийн дахин үнэлгээнд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 3,147,400.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,000,847.2 мянган төгрөгөөр бууруулж 2,146,552.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн тодотголоор 2,430,457.7 мянган төгрөгөөр баталж, 283,904.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн захирагчийн төсөвт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 5 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2,422,457.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 8,000.0 мянган төгрөгийн нийт 2,430,457.5 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,392,457.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 9,177.1 мянган төгрөгийн өөрийн орлогыг архивын лавлагааны орлого, хүний эрхийн комиссын байоны түрээс зэргээс бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 2,221,025.0 мянган төгрөгийг зарцуулж, 180,609.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 91.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 7,731.8 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 15,195.9 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар, байр ашиглалттай холбоотой зардал 5,856.4 мянган төгрөгөөр буюу 2.6 хуиар, эд хогшил, урсгал

засварын зардал 1,863.4 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар, хангамж, бараа материалын зардал 1,989.7 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын Шинэ хөгжлийн зам мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд 186,085.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс,
- Архивын тасгийн хоёр гэрээт ажилтны цалингийн зардалд 18,331.6 мянган төгрөгийг архивын ерөнхий газраас,
- Дайчилгааны зардалд 504.0 мянган төгрөгийг Батлан хамгаалах яамнаас,
- Төрийн албаны нөөц бэлтгэх үйл ажиллгааны зардалд 4,216.0 мянган төгрөгийг Төрийн албаны зөвлөлөөс,
- Хог хаягдлыг бууруулах үйл ажиллагааны зардалд 79,461.7 мянган төгрөгийг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас,
- Айрагны өдөрлөгт 10,000.0 мянган төгрөгийг Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс,
- Нийгмийн хариуцлагын хүрээнд нэр бүхий 2 компаниас 27,108.0 мянган төгрөгийг хандиваар,
- Соёл, урлагын газрын үйл ажиллагааны зардалд 15,000.0 мянган төгрөгийг Сангийн яамнаас,
- Урьд оны зарим нэр төрлийн засварын зардал 605,000.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн данснаас,
- Аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон бусад чиг үүргийн үйл ажиллагааны зардалд 10,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс,
- Орхон аймгийн хамтын ажиллагааны зардалд 5,000.0 мянган төгрөгийг Орхон аймгийн ЗДТГ-аас тус тус санхүүжүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилагдсан хөрөнгө 117,513.4 мянган төгрөг, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 802,608.3 мянган төгрөг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 27,108.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15,000.0 мянган төгрөг нийт 962,229.7 мянган төгрөгийн орлого хүлээн авч, гэрээт ажалтны цалин, нийгмийн даатгалын шимтгэл 15,491.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 168,970.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаар 746,407.5 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39303 дансанд 250 нэр төрлийн 465,508.9 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг болон хасах үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн

дууссан хөрөнгөнд нэмж элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

3.7.2 Нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллийг хугацаанд нь 163, хугацаа хоцроож 6 мэдээлэл мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаандаа мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,
- Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,193,546.7 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 1,130,781.0 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 62,765.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

4.1.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 1,130,781.0 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав. Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

4.3.1 Тавилга, багаж техникийн худалдан авах зардлаас 15 нэр төрлийн ширээ сандал, кресль сэйф шкап, конторын тавилга зэрэг 33,378.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, Бараа материалын тайланд дансдын зарцуулалтад горим сорил хэрэгжүүлээхэд 29,387.7 мянган төгрөгийн бичиг хэрэг, бараа материал, шатахуун зэрэгийг хөрөнгийг зарцуулахдаа шаардах хуудсанд гарын үсэг дутуу, хүлээн авсан албан хаагчийн гарын үсэг байхгүй /хоосон шаардах хуудастай/ зэрэг зөрчлүүд байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин тавилга эд хогшил бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоож, “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

4.3.2 Төсөв, гүйцэтгэл хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбар 11-р сар, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 11-р сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 1-р сар, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 1.4.5-р саруудын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүйд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг дахин давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материал данстай холбоотой асуудал

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Бичиг хэргийн материалын тайлангийн тусгай зориулалтын материал дансанд бусад хангамжийн материал, бичиг хэргийн материал дансанд зураг, Бусад хангамжийн материал дансанд хөрөнгийн шинж чанартай ном зэрэг банйа. үлдэгдэлтэй байна..

1.2. Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

2.2. *Өгсөн зөвлөмж:*

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	***2***	***3***	***4***	***5***	***6***	***7***	***8***	***9***	***10***	***11***	***12***
1	**Булган аймгийн ЗДТГ**	**6**	**1,193,546.7**	**3**	**1,130,781.0**	**0**	**0**	**1**	**62,765.7**	**2**	**0**